“МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ БОЛОН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ БАРИМТ БИЧГИЙГ НЭГТГЭХ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АРГА ЗҮЙГ ТАНИЛЦУУЛАХ СУРГАЛТ-СЕМИНАР”-ЫГ НЭЭЖ БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ДЭД САЙД Ц.БАТБАЯРЫН ХЭЛЭХ ҮГ

Эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид Та бүхний энэ өглөөний амар амгаланг айлтган мэндчилье!

Өнгөрсөн жил Монгол Улсын Их хурлын **Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо**ноос Монгол улсын байгаль орчин, нийгэм, эдийн засгийн салбарт гарсан ахиц дэвшил болон байгаль орчны олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтэд цогц үнэлгээ хийх чиглэлийг **БОАЖЯ**-нд өгсөн юм. Үүний дагуу бид энэ талын ихээхэн туршлагатай **НҮБ-ын Ази-Номхон далайн эдийн засаг-нийгмийн комисс** болон **НҮБ-ын харьяа Европын эдийн засгийн комисс**т хамтран ажиллах хүсэлт тавьснаар “**Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ**”, “**Монгол Улсын тогтвортой хөгжлийн хэтийн төлөв**”, “**Тогтвортой хөгжилд хүрэх замнал**” – хэмээх гуравласан тойм баримт бичгүүдийг боловсруулах ажил эхэлсэн билээ.

Эдгээр баримт бичгүүдийг боловсруулах нь БОАЖЯ үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ойн хүрээнд манай яамнаас хийж байгаа томоохон ажлуудын нэг бөгөөд өнгөрсөн 30 жилийн ажлын ололт амжилт, сургамжийг хөндлөнгийн үнэлээчдээр үнэлүүлэх, цаашид тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийг цогцлооход тулгарах сорилтууд, тэдгээрийг даван гарах арга замын талаар олон улсын экспертүүдийн санал зөвлөгөөг авах чухал ач холбогдолтой.

Энэ ажлыг бид Монгол Улсын Засгийн газрын хөгжлийн бодлогыг зангидагч **Үндэсний хөгжлийн газар**тай нягт хамтран гүйцэтгэж байгаа бөгөөд бид салбар хоорондын бодлогын уялдааг хангах, холбогдох төрийн байгууллагуудын чадавхыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг удаа дараа амжилттай хамтран зохион байгуулж байгааг онцлон тэмдэглэхэд таатай байна. Мөн энэхүү ажилд бусад яамд, агентлагуудын ажилтнууд цаг заваа гарган оролцож, тухайн салбарын үйл ажиллагааны талаарх мэдээллийг өгөн, ажлын уялдаа холбоог ханган оролцож байгаад гүнээ талархаж байгаагаа илэрхийлье.

Эдгээр тойм баримт бичгүүдийг нэгтгэн боловсруулах нь Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хүрээнд дэлхийн “**Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030**”, “**Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030**” болон “Монгол Улсын **Ногоон хөгжлийн бодлого**”-ыг үр дүнтэй хэрэгжүүлэх, мөн байгаль орчныг хамгаалах **НҮБ-ын суурь 3 конвенц**, тэдгээрийг дагалдах гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэх чухал ач холбогдолтой юм.

Өнөөдрийн сургалтаар та бүхэнд танилцуулах шинэ арга зүй нь хөгжлийн асуудлуудыг цогцоор нь авч үзэх, тэдгээрийг шийдвэрлэх голч цэгүүдийг олж тогтоох, улмаар хөгжлийн замналаа тодорхойлох арга барилыг багтаасан нь онцлог юм. Түүнчлэн ТХЗ-уудыг НҮБ-ын суурь 3 конвенцтой уялдуулан хэрэгжүүлэхэд Байгаль орчны стратегийн **түргэвчилсэн** үнэлгээ хийх, ТХЗ-уудын **үндэсний шалгуур үзүүлэлт**ийг тодорхойлох арга зүйг хэрхэн ашиглах талаар та бүхэнд мэдээлэл өгөх юм байна. Та бүхэн тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх арга зүйгээ шинэ аргаар тодорхойлон, салбар дундын харилцан уялдааг хангах талаар үр дүнтэй хэлэлцүүлэг хийж, нэгдсэн ойлголтод хүрнэ гэдэгт итгэлтэй байна. Ингээд та бүхний сургалт-семинарын үйл ажиллагаанд амжилт хүсье!